Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Бараа материалын дансны үлдэгдэл 2,965,273.5 мянган төгрөг болж, 672,504.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 812,441.8 мянган төгрөгийн материал худалдаж авсан, 1,115,201.5 мянган төгрөг (ОБЕГ-аас 936,432.3 мянган төгрөг, аймгийн ОНХО-аар 176,379.8 мянган төгрөг, бусад байгууллагаас 2,389.4 мянган төгрөг)-ийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, 1,240,374.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, бусад байгууллагад 14,763.9 мянган төгрөгийн материалыг шилжүүлсэнтэй холбоотой,

2. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,149,689.2 мянган төгрөг болж, 291,643.9 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дараах хөдлөл өөрчлөлттэй холбоотой байна. Үүнд:

- Улсын комиссын актаар хүлээн авсан Баянгол суманд байршилтай 299,488.2 мянган төгрөгийн өртөгтэй шатахуун түгээх станцын барилга, Алтанбулаг суманд байршилтай “Гүн нуур усан сургалтын цогцолбор”-ын 17,500.0 мянган төгрөгийн өртөгтэй гүний худаг зэрэг нийт 316,988.2 мянган төгрөгийн барилга байгууламжийг орлогод авч бүртгэснээс,
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 63, ТӨБЗГ-ын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А-1/1552 дугаар тогтоолын дагуу ОБЕГ-ын харьяа 185 дугаар ангиас 152,000.0 мянган төгрөгийн үнэтэй Ланд круйзер 76, 189,000.0 мянган төгрөгийн үнэтэй Патрол Y61, 220,000.0 мянган төгрөгийн үнэтэй шатахуун зөөврийн Хово зэрэг нийт 561,000.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 385,435.0 мянган төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан болон 28,000.0 мянган төгрөгийн уурын зуухны тоног төхөөрөмж, 2,000.0 мянган төгрөгийн компьютер зэрэг нийт 30,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, нийт 241,867.6 мянган төгрөгийн өртөгтэй газрыг биет бус хөрөнгөд бүртгэсэн, 1,102,218.2 мянган төгрөгийн элэгдэл нэмж байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 6,626,457.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар нэмэгдүүлж баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 2,584,812.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 6,550.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 54,621.9 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардлыг 306,569.2 мянган төгрөг,
- Нормативт зардлыг 156,005.0 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 751,837.0 мянган төгрөг,
- Томилолт, зочны зардлыг 50,576.0 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 50,015.7 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 143,940.0 мянган төгрөг,
- Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлыг 39,101.1 мянган төгрөг зэрэг нийт 1,552,665.9 мянган төгрөгөөр бууруулж, **7,665,153.6** мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 791,633.8 мянган төгрөгөөр бууруулсан төсвийн тодотгол, зохицуулалт хийж нийт **6,873,519.8** мянган төгрөг (*Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 43,599.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 24,626.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 6,138.3 мянган төгрөг, нормативт зардлыг 185,586.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 103,500.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийг 11,901.8 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардлыг 7,600.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 8,246.0 мянган төгрөг зэрэг нийт **391,198.8 мянган төгрөгөөр** нэмэгдүүлж, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг **1,182,832.6 мянган төгрөгөөр** бууруулсан байна.) -өөр эцэслэн баталсан байна.*

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,873,519.8 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,871,622.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 1,892.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 4.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,856,564.9	6,854,672.8	1,892.1	99.9
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	16,954.9	16,950.0	4.9	99.9
	Дүн	6,873,519.8	6,871,622.8	1,897.0	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газар нь нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 476,014.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн 466,453.6 мянган төгрөгийг зарцуулж, жилийн эцэст 9,560.5 мянган төгрөгийг орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна. Үүнийг тодруулбал:

1. 2023 оны эцэст төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлагыг барагдуулсан 10,000.0 мянган төгрөг,
2. Шадар сайдын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 114 дүгээр тушаалаар “Өвөлжилт, хаваржилтыг хохирол багатай даван туулах, цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх” зардалд 15,000.0 мянган төгрөг,
3. ОБЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/83, 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/105, 06 дугаар сарын 27-ны өдрийн А/233, 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/309, 12 дугаар сарын 06-ны өдрийн А/438 дугаар тушаалуудаар тус газрын албан хаагчдын гамшиг, ослын үед ажилласан албан томилолтын зардалд нийт 55,486.5 мянган төгрөг,
4. ОБЕГ-ын даргын 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн МН/10 дугаар тушаалаар улсын нөөцийн 05 дугаар ангийн агуулах, конторын засварын зардалд 22,000.0 мянган төгрөг, 074 дүгээр цэгийн агуулахын дээврийн засварын зардалд 69,817.0 мянган төгрөг, 5 дугаар сарын 20-ны өдрийн МН/24 дүгээр тушаалаар 05 дугаар ангийн авто гражийн засварын зардалд 5,600.0 мянган төгрөг, 7 сарын 22-ны өдрийн МН/33 тушаалаар 05 дугаар ангийн цахилгааны агаарын шугамын засварын зардалд 10,000.0 мянган төгрөг,
5. ОБЕГ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/106 дугаар тушаалаар “Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн Зүүнбүрэн, Хүдэр сумдад үүссэн цаг үеийн шинжтэй асуудлыг шийдвэрлэх” зорилгоор 37,052.0 мянган төгрөг,
6. Аймгийн Засаг даргын захирамжаар ЗДНХ-ийн зардлаас нийт **170,871.3** мянган төгрөгийн дараах санхүүжилтүүдийг олгосон:

- 01 дүгээр сарын 22-ны А/18 дугаар захирамжаар 2023 оны үйл ажиллагааны үр дүнгээр “Тэргүүн байр” эзэлсэн шагналд **2,000.0** төгрөг,
- 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/31 дүгээр захирамжаар төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах зардалд **6,125.7** мянган төгрөг (*Нийт 17,589.7 мянган төгрөгөөс зарцуулагдаагүй 11,464.0 мянган төгрөгийг буцааж төвлөрүүлсэн.*),
- 03 дугаар сарын 04-ний өдрийн А/90 дүгээр захирамжаар “Аймгийн Онцгой комиссын шатахууны нөөц бүрдүүлэх”-д **10,000.0** мянган төгрөг, А/91 дүгээр захирамжаар аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг шинэчлэн байгуулах зардалд **17,919.3** мянган төгрөг,
- 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/131 дүгээр захирамжаар хөдөлгөөнт хяналтын цэг ажиллуулах зардалд **34,967.2** мянган төгрөг,
- 05 дугаар сарын 31-ний өдрийн А/290 дүгээр захирамжаар гол, нуурын дагуу хөдөлгөөнт болон завьт эргүүл ажиллуулах зардалд **15,046.5** мянган төгрөг,
- 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/411 дүгээр захирамжаар “Сэлэнгэ аймаг, хил орчмын бус нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулахад талуудын оролцоо” сэдэвт эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг зохион байгуулахад **11,814.6** мянган төгрөг (*Нийт 12,248.8 мянган төгрөгөөс зарцуулагдаагүй 434.2 мянган төгрөгийг буцааж төвлөрүүлсэн.*),
- 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/460 дугаар захирамжаар гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах зардалд **28,496.2** мянган төгрөг,
- 12 дугаар сарын 02-ны өдрийн А/564 дүгээр захирамжаар сум, орон нутагт ажиллах шуурхай бүлгийн зардалд **18,046.6** мянган төгрөг,
- 12 дугаар сарын 13-ны өдрийн А/579 дүгээр захирамжаар аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын зардалд **1,894.5** мянган төгрөг,
- 12 дугаар сарын 19-ний өдрийн А/589 дүгээр захирамжаар “Хүдэр сум дахь Эрэн хайх, аврах салбарын алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах” зорилгоор барилгын засварын зардалд **15,000.0** мянган төгрөг,
- 12 дугаар сарын 24-ний өдрийн А/621 дүгээр захирамжаар Сүхбаатар суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 4 эгнээ автозамын ажлаар тус байгууллагын эзэмшлийн хашааг татан буулгах, шинээр барихад гарсан зардалд 9,560.5 мянган төгрөг.

6. Аймгийн Засаг даргын 06 дугаар сарын 10-ны өдрийн А/300 дугаар захирамжаар “Гүн нуур усны сургалтын цогцолбор төвийн тохижилт”-ын ажилд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас **50,000.0** мянган төгрөг,

7. Сүхбаатар сумын Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/175 дугаар захирамжаар сумын Онцгой комиссын бэлэн байдал хангах зардалд 8,000.0 мянган төгрөг гэх мэт.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус газар нь тайлант жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авалтын босго үнээс давсан /2024 оны анх батлагдсан төсвөөр/ 45,804.0 мянган төгрөгийн нүүрс, 53,286.4 мянган

төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр гэрээ шууд байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Онцгой байдлын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Онцгой байдлын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 31/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,353,722.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 63,537.2 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Онцгой байдлын газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Гал түймэртэй тэмцэх тактикийн сургалтаас бусад сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулсан,

- Бичиг хэргийн зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд цахим сүлжээг ашиглаж төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус газар нь шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан / *оны эхэнд баталсан төсвийн хуваариар* / 45,804.0 мянган төгрөгийн нүүрс, 53,286.4 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.”, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”-ийн 1 дэх “Шууд худалдан авч болох болох төсөвт өртгийн дээд хязгаар: *Бараа-20.0 сая төгрөг, ...* ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнах, хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр худалдан авалтыг хийж гүйцэтгэх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн тус газрын худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 26,204.9 мянган төгрөгийн 7 зөрчилд албан шаардлага, 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	7	26,204.9	7	26,204.9	100.0
Зөвлөмж	2	-	2	-	100.0
Нийт дүн	9	26,204.9	9	26,204.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг **дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж** байна. Үүнд:

1. Тайлант оны эцэст буюу 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ОБЕГ-аас шатахууны талон хуваарилан өгснөөс шалтгаалж шатах, тослох материалын үлдэгдэл 35,700.0 мянган төгрөгөөр огцом нэмэгдсэн байна.

Иймд тус газрын албан хэрэгцээ, шаардлагад үндэслэн шатах, тослох материалын хэрэгцээг хангаж байх нь зүйтэй юм.

2. Тус газрын оны эхэнд батлагдсан төсвийн хуваарьт 1 дүгээр улирлын түлш, халаалтын зардлыг хүрэлцэхүйц хэмжээгээр тусгаж өгдөггүй, оны эцэст нэмэгдүүлэн төсвийн зохицуулалт хийдгээс шалтгаалан дараа оны 1 дүгээр улиралд үүсэх эрсдэлээс сэргийлж, тайлант оны түлш халаалтын зардлын хэмнэлт 30,541.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлэлгүйгээр, нүүрс нөөцөлсөн байна.

Иймд байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай тогтмол зардлын төсвийн сар, улирлын хуваарийг бодит байдалд үндэслэн үнэн зөв төлөвлөн, санхүүжилтийг олгох нь зүйтэй юм.

3. ОБЕГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Б/1760 дугаар тушаалаар Онцгой байдлын байгууллагын 2023 оны “Шилдэг аврагч-гал сөнөөгч”-өөр шалгарсан гэх үндэслэлээр тус газрын ГТУА 40 дүгээр ангийн аврагч-гал сөнөөгч С.Билгүүнд 6 сарын албан тушаалын үндсэн цалингаар шагнасан байна.

Иймд мөнгөн шагналыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.3¹-т заасны дагуу олгох нь зүйтэй юм.

4. Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт салбарын болон аврах ажиллагааны зориулалтын тоног төхөөрөмж, бараа материалын бүртгэлийн онцлог, элэгдлийн хугацааг бүрэн тусгаагүйгээс тус газарт хэрэглэгдэж байгаа хийлдэг завь, мотор зэрэг нь үндсэн хөрөнгө, бараа материалын дансны аль алинд нь бүртгэлтэй байна.

Иймд хууль, тогтоомжид нийцүүлэн, салбарын болон аврах ажиллагааны зориулалтын тоног төхөөрөмж, бараа материалын бүртгэлийн онцлогийг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 47,467.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, 4 зөрчилд албан шаардлага, 1 зөрчилд зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

5.1 Албан шаардлага

1. Тус газрын дарга Г.Галбадрахад өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй нийт **2,433.0** мянган төгрөгийн урамшууллыг тайлант жилийн цалингийн батлагдсан төсвөөс олгож, зардлаар тайлагнасан байна. Үүнд:

- ОБЕГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/1767 дугаар тушаалыг үндэслэн 2023 оны сүүлийн хагас жилийн үр дүнгийн урамшуулалд 811.0 мянган төгрөг,
- Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Б/41 дүгээр захирамжийг үндэслэн нэг сарын үндсэн цалинтай тэнцэх 1,622.0 мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”: 14.4.3: “бүх өр төлбөр” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ ... Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд өр төлбөрийг тусгасны үндсэн дээр дараа жилийн батлагдсан төсвөөс барагдуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2.Тайлант онд “Тэргүүний байгууллага”, “Шилдэг аврагч-гал сөнөөгч”, “2023 оны байгууллагын шилдэг”-ээр шалгарсан гэх үндэслэлээр нийт **31,034.0** мянган төгрөгийн шагнал урамшууллыг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас бус цалингийн зардлаас олгож, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулан гүйцэтгэлийг санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнаагүй байна.Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/18 дугаар “Тэргүүний байгууллага, сум, тосгон, баг шалгаруулах тухай” захирамжийг үндэслэн тус газрын дарга Г.Галбадрахад 1 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,622.0 мянган төгрөгийн,
- Тус газрын даргын 02 дугаар сарын 05-ны өдрийн Б/11 дүгээр тушаалаар Онцгой байдлын байгууллагын 2023 оны “Шилдэг аврагч-гал сөнөөгч”-өөр шалгарсан гэх үндэслэлээр ГТУА 40 дүгээр ангийн аврагч-гал сөнөөгч С.Билгүүнд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх 6,600.0 мянган төгрөгийн,
- Тус газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн Б/131 дүгээр тушаалаар “Газрын даргын нэрэмжит шагнал”, “Оны шилдэг анги, хамт олон, салаа, бүлэг”, “Оны шилдэг алба хаагч”, “Оны шилдэг офицер, удирдагч”, “Оны шилдэг үйлчилгээний ажилтан”-аар шалгарсан гэх үндэслэлээр 15 албан хаагчийн шагналд нийт 22,812.0 мянган төгрөг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно*” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна. гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

3.Тус газар нь байгууллагын цаг үеийн мэдээ мэдээллийг олон нийтэд түгээх, таниулах зорилгоор Сэлэнгэ шүтээн ХХК-ийн захирал Д.Туултай “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, ажлын хөлсөнд 6,000.0 мянган төгрөгийг ажил гүйцэтгэсэн тайлан буюу анхан шатны баримтгүйгээр олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*”, 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний 2.2.7 дахь “*Гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу явцын тайланг тухай оны 7 дугаар сарын 10-ны өдрийн дотор болон 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайлагнана*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил, гүйлгээг гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Илчит хурдаст ХХК, Даймонд Очир ХХК-иас нийт 8,000.0 мянган төгрөгийн хандивын орлого төвлөрүүлж, тус газрын 05 дугаар ангийн 018 дугаар цэгийн албан конторын засварт 6,000.0 мянган төгрөг, бүжгийн хувцас, “Өсвөрийн аврагч” тэмцээний медаль хийлгэхэд 2,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь “Зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно.”, 25.2.1: “эмнэлгийн үйлчилгээ”, 25.2.2: “бүх шатны боловсролын үйлчилгээ”, 25.2.3 дахь “соёлын үйлчилгээ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж, хандивын орлого төвлөрүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

1. Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэргийн хөтлөлт-тэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд авто тээврийн хэрэгслүүдэд хийгдсэн засвар, үйлчилгээг “Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэрэг”-т бүрэн бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Засвар үйлчилгээ хийсэн тохиолдолд “Авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын хувийн хэрэг”-ийг хөтөлж, урсгал засварын ажлуудыг бүртгэж, тээврийн хэрэгсэл ашиглалтын хяналтыг сайжруулах.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
-----	---	---	---	---	---	---	---	---	---	---	---	---

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөрөөр тусгагдаагүй зардлыг тайлант оны төсвөөс санхүүжүүлж, зардлаар тайлагнасан.	1	2,433.0			1	2,433.0						
Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	31,034.0			1	31,034.0						
Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэсэн	1	6,000.0			1	6,000.0						
Хандивын орлого төвлөрүүлж, зарцуулсан.	1	8,000.0			1	8,000.0						
Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэсэн.	1	-					1	-				
Дүн	5	47,467.0	-	-	4	47,467.0	1	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								

Босго үнээс давсан хоол, хүнсний материал, нүүрсний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.	1	99,090.4	-	-	1	99,090.4	-	-
Дүн	1	99,090.4	-	-	1	99,090.4	-	-
Нийт дүн	1	99,090.4	-	-	-	99,090.4	-	-